



**ТЕХНИК ИМПОРТ ХУВЬЦААТ
КОМПАНИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТОГТООЛ**

2026 оны 03 сарын 09 өдөр

Дугаар 03

Улаанбаатар хот

**Хувьцаа эзэмшигчдийн ээлжит
хурлыг зарлан хуралдуулах тухай**

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 59.4, 60.1, Техник импорт ХК-ийн Дүрмийн 7.47.3 дахь заалт, Санхүүгийн Зохицуулах Хорооны 2018 оны 377 дугаар тогтоолоор баталсан “Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх журам”-ын 2.1 дэхь хэсэг, Техник импорт ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2026 оны 03-р сарын 09-ний өдрийн хурлын шийдвэрийг тус тус үндэслэн

“Техник импорт” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2026 оны 03-р сарын 09-ний өдрийн хурлаас **ТОГТООХ нь:**

1. Техник импорт ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг 2026 оны 04-р сарын 30-ны өдрийн 15.00 цагт Баянгол дүүрэг, 28-р хороо, Энхтайваны өргөн чөлөө-125, Техник импорт ХК-ийн “Хурлын танхим”-д хуралдуулсугай.
2. Техник импорт ХК-ийн 2026 оны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар дараахь асуудлуудыг хэлэлцэхээр тогтоосугай. Үүнд:
 - 2025 оны компанийн жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ын гаргасан дүгнэлт
 - 2025 оны ногдол ашгийн тайлангийн талаарх ТУЗ-ын шийдвэр
 - 2025 оны компанийн жилийн үйл ажиллагааны тайлан
 - 2026 оны компанийн жилийн үйл ажиллагааны төлөвлөгөө
 - 2025 оны компанийн ТУЗ-ын үйл ажиллагааны тайлан
 - 2026 оны компанийн ТУЗ-ын ердийн болон хараат бус гишүүдийг сонгох
3. “Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх журам”-ын 2.5-д заасны дагуу хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг 2026 оны 04-р сарын 01-ний өдрөөр тогтоосугай.
4. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцох эрхтэй Хувьцаа эзэмшигчдийг УЦГХТ ХХК-иас 2026 оны 04-р сарын 01-ний өдөр (бүртгэлийн өдөр)-өөр гаргасан хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалтыг үндэслэн тогтоосугай.





**ТЕХНИК ИМПОРТ ХУВЬЦААТ
КОМПАНИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТОГТООЛ**

___ оны ___ сарын ___ өдөр

Дугаар ___

Улаанбаатар хот

5. Компанийн 2026 оны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг 2026 оны 04-р сарын 30-ны өдөр хуралдуулахаар шийдвэрлэсэнтэй холбогдуулан хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын зар /Хавсралт1/-ыг Санхүүгийн Зохицуулах Хорооны 2018 оны 12-р сарын 14-ний өдрийн 377 дугаар тогтоолоор баталсан “Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх журам”-д заасны дагуу Хувьцаа эзэмшигчдэд хүргэсүгэй.
6. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг холбогдох хууль тогтоомж, дүрэм, журамд нийцүүлэн зохион байгуулж явуулахыг Хурал зохион байгуулах комисст даалгасугай.
7. 2026 оны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын даргаар Дашдондог овогтой Ганцэцэгийг томилсугай.
8. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын Тооллогын комиссын даргаар Д. Пүрэвсүрэн, гишүүнээр Б. Баярмааг тус тус томилсугай.
9. Компанийн тухай хуулийн 67.3, 67.4-т заасан эрх, үүргийг хэрэгжүүлж санал хураалтын дүнг үнэн, зөв гаргаж хариуцлагатай ажиллахыг Тооллогын комисст үүрэг болгосугай.
10. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг хуралдуулахтай холбогдуулан хуралд оролцох эрх бүхий хувьцаа эзэмшигчид нь Хавсралт2-т заасан бичиг баримттай танилцах бүрэн эрхтэй болохыг дурьдсугай.
11. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын хэлэлцэх асуудлаар саналын хуудсаар санал хүлээн авах эцсийн хугацааг 2026 оны 04-р сарын 27-ны өдрийн 18:00 цагаар тасалбар болгосугай.
12. Хурал хуралдуулах тухай шийдвэрийг гаргаснаас хойш 3 хоногийн дотор Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал хуралдуулах тухай ТУЗ-ын тогтоол, холбогдох баримт материалыг Хороо болон Монголын Хөрөнгийн бирж ТӨХК-д тус тус хүргүүлэхийг ТУЗ-ын нарийн бичгийн дарга О.Бүжинлхамд үүрэг болгосугай.



Т. Тунгалар